



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ**

2023 оны 11 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар А/152, А/388

Улаанбаатар хот

МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ЖАГСААЛТ, ХУВЬ, ХУГАЦААГ БАТЛАХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэхь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- 1."Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацаа"-г хавсралтаар баталсугай.
- 2.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт үүрэг болгосугай.
- 3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйчилгээний газар газар /А.Өнөржаргал/-т тус тус даалгасугай.
- 4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.
- 5.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЧИНЗОРИГ